

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050”, “Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны бодлогын баримт бичиг, 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д заасны дагуу Даатгалын салбарын эрх зүйн шинэчлэлтийг үе шаттайгаар хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус даалгасан.

Үүний дагуу 2021 оны 12 дугаар сард Сангийн сайд, Хууль зүйн сайд хамтран Даатгалын тухай хуулийн үзэл баримтлалыг баталж байсан бол 2024 оны 3 дугаар сард тус үзэл баримтлалыг шинэчлэн батлаад байна.

Монгол Улсын Их Хурлаас Даатгалын тухай хуулийг анх 1997 онд баталж, 2004 онд шинэчлэн найруулсан бөгөөд энэхүү хуулиар даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулж ирсэн. 2004 оноос хойш Даатгалын тухай хуульд 16 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын даатгалын зах зээл дээр тусгай зөвшөөрөл бүхий ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 2, давхар даатгалын 1 компани, 63 даатгалын зуучлагч, 24 даатгалын хохирол үнэлэгч, 2416 даатгалын төлөөлөгч тус тус үйл ажиллагаа явуулж, 700 гаруй даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг 1.3 сая гаруй даатгуулагч иргэд, байгууллагад хүргэж ажилласан байна. Үүнээс гадна, даатгалын зах зээлд даатгалын актуарч, аудитор зэрэг 200 гаруй даатгалын мэргэжлийн оролцогчид үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд даатгалын мэргэжлийн үйл ажиллагаа, үйлчилгээний эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэхийн хэрээр тус салбар илүү мэргэшин төрөлжих хандлагатай болж байна.

2023 онд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 392.0 тэрбум төгрөгийн хураамжийн орлого төвлөрүүлж, давхар даатгалын хураамжид 141.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 120.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон бол нийт хөрөнгийн хэмжээ 485.5 тэрбум төгрөг байна. Харин давхар даатгалын компанийн хөрөнгө 65.9 тэрбум төгрөг, салбарын хэмжээнд нийт хөрөнгийн хэмжээ 551.4 тэрбум төгрөгт хүрээд байна. Энэхүү үзүүлэлтийг сүүлийн 5 жилийн өмнөх буюу 2019 оны мөн үетэй харьцуулахад даатгалын компаниудын нийт хөрөнгө 50.7 хувь, даатгалын хураамжийн орлого 100.7 хувь, олгосон нөхөн төлбөрийн хэмжээ 93.4 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байгаагаас харахад тус салбарт тодорхой хэмжээний өсөлт ажиглагдаж байна. Гэсэн хэдий ч салбарын хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох даатгалын гүнзгийрэлт буюу ДНБ-д даатгалын хураамжийн орлогын эзлэх хувь 0.58% байгаа нь дэлхийн дунджаас даруй 11-12 дахин бага, нэг хүнд ногдох даатгалын хураамжийн хэмжээ буюу даатгалын нягтрал 113,377.4 төгрөг байгаа нь дэлхийн дунджаас даруй 29-30 дахин бага байна. Эдгээр үзүүлэлт нь даатгалын салбарын хөгжил хангалтгүй, даатгалын хүртээмж муу байгааг бидэнд анхааруулж байгаа хэдий ч нөгөө талаас манай улсын даатгалын салбар хөгжлийн эхэн үедээ байгаа буюу цаашид энэ хэмжээгээр хөгжих боломж бий гэдгийг сануулж байна.

Түүнчлэн, даатгалын компаниуд 2019-2023 онд хураамжийн нийт орлогын 29.8 хувийг буюу нийт 403.1 тэрбум төгрөгийг олон улсын давхар даатгалын хураамжид зориулан гадагш шилжүүлсэн бол эргүүлэн нөхөн төлбөрт дунджаар 47.6 тэрбум төгрөгийг буцаан шилжүүлэн авсан байна. Энэ нь дотоодын даатгагч нарын хүчин чадал хангалттай хэмжээнд хүрээгүй байгаатай холбоотой бөгөөд цаашид гадагш гарч буй валютын урсгалыг бууруулах, дотоодын даатгагч нарыг чадавхжуулах, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогын түвшинд дэмжих шаардлагатай байгааг харуулж байна.

Олон улсад даатгалыг амьдралын болон амьдралын бус гэж ангилж үздэг бөгөөд Монгол Улсад мөрдөгдөж буй зохицуулалтаар даатгалыг ердийн болон урт хугацааны гэж ангилж байна. Гэвч тэдгээрийн хоорондын зааг ялгааг нарийвчлан зохицуулаагүйгээс даатгуулагч нар даатгалын гэрээг буруу ойлгох, ердийн даатгалын компаниуд урт хугацааны даатгалын шинж чанарыг агуулсан бүтээгдэхүүнийг борлуулах зэрэг тохиолдлууд гарсаар байна. Иймд даатгалын ангиллын зааг ялгааг тодорхой болгох, ангиллын нэршлийг хэрэглэгчдэд илүү ойлгомжтойгоор томъёолох хэрэгцээ бий болоод байна. Мөн урт хугацааны хөгжлийн бодлого, нийгэм эдийн засгийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан хүртээмжтэй даатгал, урт хугацааны даатгалын зохицуулалтыг боловсронгуй болгож, тэтгэвэр, хуримтлалыг бодлогоор дэмжин ажиллах шаардлагатай байна.

Түүнчлэн тодорхой төрлийн мэргэжлийн онцлогоос шалтгаалан заавал даатгуулахаар тусгасан, заавал даатгалын шинж чанар бүхий хэд хэдэн даатгалын хэлбэрүүд бусад салбарын хуулиудад тусгагдаж, зохицуулагддаг хэдий ч заавал даатгалын нэгдсэн бодлого зохицуулалтгүйн улмаас тэдгээр хуулийн хэрэгжилт, үр дүн хангалтгүй хэвээр байна.

Техник технологийн хөгжил, даатгалын салбарын цахимжилттай холбоотойгоор даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээг даатгуулагчдад ойртуулах, зардлыг бууруулах боломж нээгдээд байгаа боловч өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэх үйл явцад баримт бичгийг заавал бичгээр үйлдэх, баталгаажуулах шаардлагууд хэвээр үйлчилсээр байна. Иймд даатгалын салбарын оролцогчдод цахим дэвшилтэт техник технологид суурилсан даатгалын үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж, хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

Олон улсад оновчтой даатгалын тогтолцоо нь нийгэм, эдийн засагт томоохон дэмжлэг үзүүлж, эдийн засаг хөгжин, тэлэх тусам эргээд даатгалын хэрэгцээ шаардлага улам нэмэгдэж байдаг харилцан хамааралтай байдаг тул манай улсын хувьд даатгалын салбарын ач холбогдлыг нэмэгдүүлэх, даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, нийгэм, эдийн засагт дэмжлэг үзүүлэх салбар болгох нь чухал байна.

Иймд амьдралын даатгалыг хөгжүүлэх, заавал даатгалын нэгдсэн тогтолцоог бий болгох, технологид суурилсан даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, мэргэжлийн хөрөнгө оруулагч даатгагчдыг бий болгох, эрсдэлийн удирдлагын оновчтой тогтолцоог боловсронгуй болгох, даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг сайжруулах зорилго бүхий Даатгалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулаад байна.

Төсөлд дараах зарчмын шинж чанартай, даатгалын салбарт ач холбогдол бүхий шинэ зохицуулалтуудыг нэмж, өөрчлөн найруулж тусгасан. Үүнд:

Эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах зорилгын хүрээнд давхар даатгалын үйл ажиллагааны тогтолцоог боловсронгуй болгох, дотоодын даатгагч нарын чадавхыг нэмэгдүүлэх, гадагш урсах валютын урсгалыг бууруулах зорилгоор давхар даатгалын тодорхой хувийг дотоодын давхар даатгагчид даатгуулах зохицуулалтыг тусгасан.

Мөн даатгалын эрсдэл шилжүүлэх уламжлалт бус арга хэрэгслийг хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх зохицуулалтыг тусгаснаас гадна даатгагчийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, даатгалын компаниудын эрсдэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, даатгалын хувьцаат компани, компанийн засаглал, мэдээллийн ил тод байдалд тавигдах шаардлага, түүний хяналт, зохицуулалтын талаар тусгалаа.

Даатгалын зах зээл өндөр хөгжсөн орнуудын хувьд даатгалын зах зээлийн бүтэц буюу амьдралын /урт хугацааны/ болон амьдралын бус даатгал /ердийн даатгал/-ын харьцаа 55/45 байдаг бол манай улсын хувьд уг харьцаа нь 1/99 байна. Иймд даатгалын ангиллыг олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, амьдралын даатгалын тодорхойлолтыг илүү нарийвчилж, тогтолцоог нь боловсронгуй болгох, урт хугацааны хөрөнгө оруулалт хийх боломжийг бүрдүүлэх зэргээр амьдралын даатгал, тэтгэвэр, хуримтлалыг хөгжүүлэх, түүнийг бодлогоор дэмжих суурь зохицуулалтуудыг бий болгосон.

Даатгалын үйл ажиллагаанд цахим болон дэвшилтэт техник технологийг ашиглах боломжийг бүрдүүлж, хөгжүүлэх, эрх зүйн орчныг бий болголоо. Тухайлбал, даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөрийн хүсэлт гаргах, нөхөн төлбөр олгох, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргах, даатгагчийн санхүүгийн болон бусад мэдээллийг олон нийтэд мэдээлэх болон хяналт, шалгалт хийхэд шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайлбарыг ирүүлэх зэрэг аливаа үйл ажиллагаанд даатгалын салбарын мэргэжлийн оролцогчид цахим хэлбэрийг ашиглах боломжийг бүрдүүлсэн зохицуулалтыг бий болгосон.

Заавал даатгалын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын хуулиудад заавал даатгуулахаар тусгагдсан даатгалын үйл ажиллагааг заавал даатгал гэж тодорхойлон, тусгайлсан харилцааг тухайн хуулиар, зохицуулаагүй бусад харилцааг Даатгалын тухай хуулиар зохицуулахаар тусгалаа.

Даатгалын салбарын тогтвортой байдлыг хангах, заавал даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор өнөөгийн практик хэрэгцээ, шаардлага, олон улсын сайн туршлагад үндэслэн заавал даатгалын баталгаат сангийн зохицуулалтыг бий болголоо. Заавал даатгалын баталгаат сан нь даатгагч дампуурах, түүний улмаас заавал даатгуулагч хохирох эрсдэлээс хамгаалах, салбарын тогтвортой байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Салбарын дэд бүтцийг хөгжүүлэх, бусад зохицуулалтыг сайжруулах зорилгын хүрээнд салбарын мэдээллийн сангийн тогтолцоог бүрдүүлэх, даатгалын мэргэжлийн байгууллагыг байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх, даатгалын хохирол үнэлэгч, даатгалын орлогын шимтгэлтэй холбоотой зохицуулалтыг шинэчлэн, сайжруулах зэргээр холбогдох өөрчлөлтүүдийг хуулийн төсөлд тусгасан.

Хуулийн төсөл батлагдсанаар даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчин сайжирах, даатгалын салбар дахь эрсдэлийн удирдлагын тогтолцоо боловсронгуй болох, дотоодын даатгагч нарын чадавх нэмэгдэх, даатгалын үйл ажиллагааны эрх зүйн орчны тодорхойгүй байдал буурах, даатгалын зах зээлийн бүтэц тэнцвэржих зэрэг эерэг нөлөөг үзүүлнэ. Үүний үр дүнд, даатгалын хамрагдалт, хүртээмж нэмэгдэх, даатгалын зах зээл өргөжих, даатгалын салбарын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл нэмэгдэхээс гадна урт хугацаандаа даатгалын салбарыг хөгжүүлэх эрх зүйн суурь бүрэлдэн бий болох ач холбогдолтой болно.